



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/911

Улаанбаатар хот

Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Эрх шилжүүлэх тухай" Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/69 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хот тохижилт, нийтийн аж ахуй, барилгын засвар, шинэчлэлтийн ажлын жагсаалт"-ын 3, 4, 8 дахь заалтыг хавсралт ёсоор өөрчилсүгэй.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэлээр нь хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Мишээлт)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, "Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлтийн ажил (БЗД), Сэлбэ голын явган хүний гүүр, тохижилтын ажил (БЗД, 25 дугаар хороо), Ухаалаг усан сан (СХД, 31 дүгээр хороо)" төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, "Цахилгаан шат шинэчлэх ажил (БЗД, 6 дугаар хороо)"-д захиалагчийн хяналт тавьж ажиллахыг "Улаанбаатар лифт" ОНӨТҮГ (Д.Ган-Эрдэнэ)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (М.Баяраа)-т тус тус даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/508 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

111020004471

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 01-ны өдрийн
11/01 дугаар захирамжийн
хавсралт

"ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ" НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
01 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДРИЙН А/69 ДҮГЭЭР ЗАХИРАМЖИЙН
1 ДҮГЭЭР ХАВСРАЛТААР БАТЛАГДСАН "НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХОТ
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙ, БАРИЛГЫН ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛТИЙН
АЖЛЫН ЖАГСААЛТ"-ААР БАТЛАГДСАН 3, 4, 8 ДАХЬ ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭНД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ЖАГСААЛТ

(сая төг)

| № | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | Төсөвт өртөг | 2022 онд санхүүжих дүн |
|---|--|---------|--------------|------------------------|
| 3 | Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлтийн ажил (БЗД) | 2022 | 150.0 | 150.0 |
| | Цахилгаан шат шинэчлэх ажил (БЗД, 6 дугаар хороо) КЗ | 2022 | 140.0 | 140.0 ✓ |
| 4 | Сэлбэ голын явган хүний гүүр, тохижилтын ажил (БЗД, 25 дугаар хороо) | 2022 | 110.0 | 110.0 |
| 8 | Ухаалаг усан сан (СХД, 31 дүгээр хороо) | 2022 | 40.0 | 40.0 |
| | ДҮН | | 440.0 | 440.0 |